

## **Х-1, Д-1, ХН-113, НУГАЛБАР-5**

### **БИЧГИЙН ГАЗРУУДЫН ЗАРЛАГЫГ ТӨСӨВЛӨН БОДОХ ДАНС**

#### **ЗОХИОХ ЗААВАР ДҮРЭМ**

Хавчуулсан маягийг үзвээс төсөвлөн бодсон данс илтгэл данс болгон хуваан зохиоход юуны урьд илтгэл дансыг зохиомуй. Зохиоход дансны нүүр дээр харьяат газрын нэр зохиосон он сар өдрийг тодорхойлон цааш төсөвлөн бодсон зүйлийн зарлагыг илтгэл дансны тус тус хамарт бичээд хэрэв нэгэн хамарт үл багтах аваас хүрэлцэх тооны хамар цаасыг хэрэгсгүй. Хуудас бүрийн маягийн адил шугамдаж бичээд дэс дараалан нэгэн дэвтэр болгомуй

**Нэгдүгээр зүйлийн** цалингийн зарлагад харьяат газрын орон тооны ёсоор албан хаагчдын тушаал зэргийн дугаар сар тутмын ба нэгэн жилийн цалин сул орон зэргийг тодорхойлоод нэг жилийн цалингийн бүх зарлагын дүнг бичсэн дараа орон тоог засгийн газар хэзээ баталсанг тэмдэглэмүй.

**Хоёрдугаар зүйлийн** бичгийн зарлагад харьяат газар төсөвлөн бодсон оны дотор хэрэгсэх телефон шуудан бичиг төмөр утас хэвлэлийн зарлага бичгийн хэрэгслийн зүйлүүдийн тоо нэг бүрийн үнэ бүгдийн үнийг тодорхойлон эл зүйлийн нэг жилийн зарлагын дүнг бичсэний дараа бичгийн хэрэгслийн тоо зэргийг бодохуйд юу баримталсанг тайлбарламуй.

**Гуравдугаар зүйлийн** түлшний зарлагад харьяат газар хэрэгсэх түлээ, зуухын тоогоор маягийн дотор тайлбарлан өгүүлсэн хэмжээг баримтлан бодохуйд хэрэгсэх түлээний сажийн тоо саж бүрийн үнэ тодорхойлон нэг жилийн зарлагын дүнг бичмүй.

**Дөрөвдүгээр зүйлийн** лаа гэрлийн зарлагад харьяат газар хэрэгсэж бүхий цахилгаан гэрлийн лампны тоо хэрэгсэх лампны тос лаа үнийг тодорхойлон нэг жилийн гэрлийн бүх зарлагын дүнг бичсэн дараа гэрлийг ямар учир хэрэгсэж буйг тайлбарламуй

**Тавдугаар зүйлийн** орон байшингийн зарлагад харьяат газрын орон савыг ариун цэвэр агуулах төсөвлөн бодсон оны дотор аар саар засварын зарлага зэргийн үнэ тодорхойлон эл зүйлийн нэг жилийн зарлагын дүнг бичсэн дараа хэрэгсэх тайлбарла тэмдэглэмүй.

**Зургаадугаар зүйлийн** морь ба хөсөг ачлага жич нааш цааш албаны хэргээр томилогдогчдын зарлагад хэрэв харьяат газар өөрийн хөсөг ачлагатай буй аваас морь үхэр тэрэгний тоо хэрэгсэх аваас овъёос морь талхах тэрэг ба тоногийг сэлбэн засах зарлагыг тодорхойлмуй. Хэрэв харьяат газар өртөөг хэрэгсэх хэмээвээс морь ба бусад малыг тодорхойлоос гадна хүмүүсийг гадаадад томилох аваас томилогдсон зарлага мөнгөний тоог мөн энэ зүйлд тодорхойлон эл зүйлүүд нэг жилийн бүх зарлаганы дүнг бичсэн дараа хэрэгсэх тайлбарыг тэмдэглэмүй.

**Долоодугаар зүйлийн** хурал номын зарлагад хурал номын зарлагыг тодорхойлон нэг жилийн бүх хурал номын зарлагын дүнг бичсэний дараа тайлбарлыг тэмдэглэмүй.

**Наймдугаар зүйлийн** элдэв зарлагад дээр дурдсан зүйлүүдийн зарлагад үл нийлэлцэх олон зарлагыг тодорхойлон дээр дурдсан цалингаас бусдаас олон зүйлүүдийн зарлагын зуун хувиас арван хувийг магадлашгүй зарлага болгон элдэв зарлагын зүйлд нэмэн бодож нэг жилийн зарлагын дүнг бичсэн дараа хэрэгсэх тайлбарлыг өгүүлмүй. Илтгэл дансны зохиосон дараа зүйл зохилын дүн тоог төсөвлөн бовсон данс хүү бичээд гарын зураг зурж тамга дараад сангийн яамнаа хүргүүлмүй. Аливаа яам ба мөн яамны захиргааны өөртөө

тогтнох газруудын зарлагуудыг тус тус төсөвлөн бодохуйд энэхүү дүрмийг нэгэн адил баримтлан зохиомуй. Аль нэгэн газраас зарлагыг төсөвлөн бодсон оны дотор шинэ орон байшин байгуулах хуучинг шинэтгэн сэлбэн засах зэргийн нэгэн удаа үлэмхэн мөнгө зарцуулах аливаа үйлдвэрийн үйлдэх аваас тухай бүр зарлагыг төсөвлөн бодсон данс угааж учир бүртгэн тайлбарлаж тусгай мэдүүлмүй. Төсөвлөн бодсон дансад дурдсан зүйлүүдийн үнийг сангийн яамны аж үйлдвэрийн хэлтсээс лавлаж баримтлаваас зохимуй. Бусад үнийг баримтлан зохиовоосзохиосон дансыг хүлээхээс дээр арван хоёрдугаар оны зарлагыг төсөвлөн бодсон данс арван гуравдугаар оны цагаан сарын шинийн нэгэн хүртэл хүчин төгөлдөр болох тул арван хоёрдугаар оны дотор төгсөөгүй зарлагыг арван гуравдугаар оны төсөвлөн бодсон данс хүү тэмдэглэвээс зохимуй.